

Монголын Эдийн Засгийн Сарын Тойм

2016 оны 1 дүгээр сар



THE WORLD BANK

IBRD • IDA | WORLD BANK GROUP

<http://www.worldbank.org/mongolia>

- Экспорт 2015 оны сүүлийн 3 сард огцом буурсан нь гадаад эрэлт өргөлжлэн суларч байгааг илтгэж байна.
- Нийт импорт өргөлжлэн саарсан ч машин, тоног төхөөрөмжийн импорт сүүлийн 2 сард нэмэгдэв.
- Гадаад валютын улсын нөөц буурч оны эцэст 1,323 сая ам.долларт хэрэв. Нэг ам.доллар 2016 оны 1 дүгээр сард 2000 гаруй төгрөгтэй тэнцэв.
- Инфляци өргөлжлэн буурч оны эцэст жилийн 2 хувь хэрэхгүй төвшинд хэрэв.
- Монгол улсын засгийн газрын бондын хүү 11 хувийг давав.
- Төвбанк бодлогын хүүгээ 1 нэгж хувиар бууруулж жилийн 12 хувь болгов.
- Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хэтэлбэр барилгын салбарын идэвхжлийг дэмжихэд чиглэн өргөлжлэхээр байна.
- Нэгдсэн төсвийн алдагдал оны эцэст 1,163 тэрбум төгрөгт хүрч төсвийн сүүлийн тодотголоор батлагдсан алдагдлын хэмжээтэй ойролцоо гарав.

Түүхий эдийн дэлхийн зах зээлийн идэвхжил хурдтай суларч буй орчинд 2015 оны сүүлийн 3 сард экспорт огцом агшлаа. 2015 оны эхний 9 сард экспорт жилийн 12 хувиар саарсан бол сүүлийн 3 сард 36 хувиар буурчээ. Мөн хугацаанд нүүрсний экспортын хэмжээ 43 хувиар саарсан нь үнэ болон биет хэмжээний бууралтаас шалтгаалжээ. Энэ нь голчлон Хятадын эрэлтээс шалтгаалав. Оюу толгойн үйлдвэрлэсэн зэсийн экспортын биет хэмжээ өндөр байгаа ч зэсийн үнэ 43 хувиар буурсан орчинд нийт зэсийн экспорт 37 хувиар буураад байна. Нийт экспортын хэмжээ 2015 онд 4,669 сая ам.доллар болж 2014 оны 5,774 сая ам.доллартай харьцуулахад 19.1 хувиар буурчээ.

Гэвч газрын тосны үнэ буурсан, дотоод эрэлт саарсан зэрэгтэй уялдан худалдааны тэнцэл 4 дүгээр улиралд 188 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт

экспорт 2015 оны сүүлийн улиралд жилийн 21 хувиар буурчээ. Нийт импорт 2015 онд 3,797 сая ам.долларт хүрч 2014 оны 5,236 сая ам.доллартай харьцуулахад 27.5 хувиар агшчээ. Газрын тосны үнийн уналт нь 4 дүгээр улиралд нийт шатахууны импорт жилийн 43.5 хувиар буурахад нөлөөллөө. Гэвч 2012 оны сүүлээс тасралтгүй хурдтай буурч байсан машин, тоног, төхөөрөмжийн импорт оны сүүлийн 2 сард жилийн 18.7 хувь болон 6.8 хувиар тус тус өссөн нь 2016 онд үргэлжлэн өсөх болзошгүйг илтгэж байна.

2015 оны сүүлийн 3 сард төлбөрийн тэнцлийн алдагдал 95.6 сая ам.доллар байв. Урсгал тэнцлийн алдагдал 4 дүгээр улиралд 135 сая ам.доллар байсан бөгөөд орлогын болон үйлчилгээний дансны тэнцэл 420 сая ам.долларын алдагдалтай гарсан нь худалдааны тэнцлийн ашгаас өндөр байв. ГШХО-ын цэвэр урсгал дээрх хугацаанд 216 сая ам.доллар байсан

бөгөөд энэ нь голчлон 12 дугаар сард компани хоорондын өглөг нэмэгдсэнээс шалтгаалав. Азийн хөгжлийн банкны 100 сая ам.долларын зээл болон арилжааны банкуудын 257 сая ам.долларын гадаад зээллэг нь төлбөрийн тэнцлийн алдагдал буурахад голлох нөлөөг үзүүлээ. Төлбөрийн тэнцлийн дарамт 10-12 дугаар сард бага байсан тул Төвбанк 12 дугаар сард своп шугамын эргэлт төлөлт болгон 234 сая ам.долларыг Хятадын ардын банкинд төлөв. Оны эхний 6 сард своп хэлцлээр 632 сая ам.долларыг авч ашиглаад байсан юм.

Гадаад валютын улсын нөөц 9-11 саруудад 1.4 тэрбум ам.долларт тогтвортой байсан ч 12 дугаар сарын эцэст 1,323 сая ам.доллар болж буурсан нь 3 сарын импортын хэрэгцээг хангах түвшин юм. Гадаад валютын улсын нөөц 2014 оны эцэст 1,649 сая ам.доллар байсан бол сүүлийн 12 сард 326 сая ам.доллараар буурав.


Нэг ам.доллар 1 дүгээр сард 2,011 төгрөгтэй тэнцэв. Түүхий эдийн экспортод тулгуурласан бусад орнуудын валютын ханш огцом сулраад байгаа хэдий ч

төгрөгийн ам.доллартай харьцах ханш 8 дугаар сарын дундаас хойш 1,900-2,000 хооронд тогтвортой байлаа. Төвбанк 7-9 дүгээр саруудад гадаад валютын интервенцээ ихээхэн нэмэгдүүлсэн бол харин төлбөрийн тэнцлийн нөхцөл байдал харьцангуй тогтвортой байсан оны сүүлийн 3 сард интервенцийн хэмжээгээ огцом бууруулжээ. Глобал санхүүгийн зах зээлийн хэлбэлзэл нэмэгдсэн орчинд энэ оны эхний сард төгрөгийн ханш сулрах дарамт нэмэгдэх төлөвтэй байна.

Оюу толгойн далд уурхайн төслийн санхүүжилтийн гэрээнд 2015 оны 12 дугаар сарын 16-нд 2 тал гарын үсэг зурав. Уг төслийн санхүүжилт нь ирэх онуудад Монголын эдийн засагт 4.4 тэрбум ам.долларыг авчрах бөгөөд эдийн засгийн гадаад тэнцэл болон эдийн засгийн идэвхжлийг дэмжихээр байна. Төслийн ТЭЗҮ, холбогдох шийдвэрүүд болон зарим төрлийн зөвшөөрөл зэрэг зайлшгүй арга хэмжээнүүд энэ оны эхний хагаст хийгдэхээр төлөвлөгдөж байгаа тул хөрөнгө оруулалт орж ирэх бодит хугацаа болон хэмжээ нь дээрх арга хэмжээнүүдийн гүйцэтгэлээс хамаарахаар байна.

Зураг 1. Импорт буурч байгаа хэдий ч экспорт огцом татарч байгаа нь урсгал тэнцэлд дарамт учруулж байна.


Урсгал болон худалдааны тэнцэл (% , у/у, 3 сарын нийлбэрээр)



Эх үүсвэр: Төвбанк, ҮСХ

Зураг 2. Нэг ам.доллар 2016 оны 1 дүгээр сард 2000 гаруй төгрөгтэй тэнцэв.

Төгрөгийн нэрлэсэн ханш, өдрөөр (MNT/USD)



Эдийн засгийн өсөлт бага түвшинд хэвээр байна. Оны эхний 6 сард эдийн засаг 3

хувиар өсч байсан бол 3 дугаар улиралд өсөлт жилийн 1.8 хувь болж удааширсан.


Хөрөнгө оруулалт 36.1 хувиар агшсан нь 3 дугаар улиралд өсөлтөд дарамт болжээ. Эцсийн хэрэглээ жилийн 5.7 хувиар өссөн нь хувийн хэрэглээний 8.4 хувийн өсөлтөөс голлон шалгаалсан бол засгийн газрын хэрэглээ жилийн 7.7 хувиар буурч гарав. Экспорт буурч байгаа ч импорт бүр хурдтай саарсан нь цэвэр экспортыг нэмэгдэхэд нөлөөлж, улмаар өсөлтөд дэмжлэг болов. Харин аж, үйлдвэрийн бүтээгдэхүүн оны сүүлийн 3 сард дөнгөж 1.8 хувиар өссөн нь 4 дүгээр улиралд эдийн засгийн өсөлт үргэлжлэн саарах боломжтойг илтгэж байна.

Уул, уурхайн салбарын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт 4 дүгээр улиралд жилийн 6.2% болж саарсан нь уул, уурхайн салбарын ДНБ-ий өсөлт саарахыг илтгэж байна. Нүүрсний үйлдвэрлэл огцом саарсан, Оюу толгойн зэсийн үйлдвэрлэлийн өсөлт мөн саарч байгаа нь уул, уурхайн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт саарахад голлон нөлөөллөө. Оюу толгой өнгөрсөн 1 дүгээр сард гаргасан тайландаа зэс болон алтны үйлдвэрлэл 2015 онд 36 ба 10.9 хувиар тус тус өссөн гэж мэдээлсэн. Гэвч Оюу толгой компаний зэс, алтны үйлдвэрлэл 2016 онд буурахаар байгаа нь үрсгал тэнцэл болон эдийн засгийн өсөлтөд нөлөөлөхөөр байна.


2015 оны сүүлийн 3 сард уул, уурхайн бус салбарын идэвхжил сул хэвээр байв. Сүүлийн улиралд боловсруулах салбарын үйлдвэрлэл жилийн 19.8 хувиар саарчээ. Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл мөн удаашралтай, дээрх хугацаанд дөнгөж 2 хувийн өсөлттэй байв. Тэвэр болон харилцаа холбооны салбарын хөтөч үзүүлэлтүүд, тухайлбал тээвэрлэсэн ачаа тээшийн хэмжээ, зорчигчийн тоо, харилцаа холбооны үйлчилгээний борлуулалт зэрэг нь мөн сүүлийн улиралд саарсан байна. Өнгөрсөн оны хөдөө, аж ахуйн салбарын гүйцэтгэл өнгөрөгч 1 дүгээр сард зарлагдсан бөгөөд малын тоо толгой 2015 онд 9.2 хувиар өссөн бол гантай байдлаас шалтгаалан ургац хураалт харин буурсан. Тухайлбал, үр тариа, улаан бүүдай 59 хувиар, хүнсний ногоо 31 хувиар, хадлан 12.7 хувиар тус тус буурчээ.

Инфляци үргэлжлэн саарч жилийн 2 хувиас доош гарав. Улсын болон УБ хотын хэмжээнд тооцсон инфляци 12 дугаар сарын эцэст харгалзан жилийн 1.9 болон 1.1 хувьтай гарав. Сүүлийн үеийн инфляцийн буурч буй хандлага нь махны нийлүүлэлт нэмэгдсэнээс, үнэ нь огцом буурснаас шалтгаалжээ. Суурь инфляци 4.8 хувь болж мөн саарчээ.

Зураг 3. ЭЗӨХний 9 сард жилийн 2.5 хувиар өссөн бөгөөд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн 4 дүгээр улиралд бага хувиар өслөө.



Зураг 4. Инфляци оны эцэст 2 хувьд хүрээгүй нь голчлон махны үнийн бууралтаас шалтгаалав.



Монгол улсын хувьд 1 дүгээр сарын сүүлээс гадаад санхүүгийн эх үүсвэрийн нөхцөл мэдэгдэхүйц чангараад байгаа

бөгөөд ЗГ-ын бондын өгөөж 11%-иас хэтэрлээ. 5 жилийн хугацаатай Чингис бондын өгөөж өмнөх оны 12 сард 8

хүрэхгүй хувь байснаа аажмаар өсөж 1 дүгээр сарын 21-ий өдөр 11 хувиас хэтэрсэн нь өмнөх 7 хоногийн 9 хувьтай харьцуулахад огцом өсөлт байлаа. Сүүлийн саруудад хөгжиж буй эдийн засгуудын хувьд гадаад зээлийн зардал өсч буйгаас гадаад санхүүжилтийн нөхцөл чангарлаа. Гэвч бусад орнуудтай харьцуулахад Монгол улсын хувьд гадаад санхүүжилтийн нөхцөл 1 дүгээр сард огцом чангарсныг сүүлийн үеийн улс төрийн нөхцөл байдалтай холбон тайлбарлаж болохоор байна. 10 жилийн хугацаатай Чингис бондын өгөөж 12 дугаар сард 9 хувь байсан бол 1 сарын сүүлд 10 хувийг давжээ. Дим сам бондын өгөөж мөн дээрх хугацаанд 12 хувиас 14 хувьд хүрч өсөөд байна. Өгөөжийн муруйгаас харахад бусад орнуудын 10 жилийн хугацаатай бондуудын өгөөжтэй харьцуулахад 5 жилийн хугацаатай Чингис бондын өгөөж өндөр байгаа нь хөрөнгө оруулагчид Монгол улсыг 2016-17 онуудад богино хугацааны өндөр эрсдэлтэй тулгарах эрсдэлтэй гэсэн хүлээлттэй байгааг илтгэж байна.

Төвбанк оны эцэст мөнгөний бодлогын ялгаатай зээлийн хэрэгслүүд (тухайлбал, овернайт зээл)-ийг ашиглан банкны секторт ихээхэн хэмжээний богино хугацааны эх үүсвэрийн дэмжлэг үзүүлэв. Төвбанкны банкуудад олгосон зээлийн үлдэгдэл өнгөрсөн 11 дүгээр сард 1,299 тэрбум төгрөг байсан бол 12 дугаар сарын эцэст 1,686 тэрбум төгрөгт хүрч өсчээ. 2011 оноос хойш Төвбанк банкуудад оны эцэст эх үүсвэрийн дэмжлэг үзүүлж, улмаар жилийн эцсийн зохистой харьцааны үзүүлэлтийг нь сайжруулах болон банкны системийн эх үүсвэрийн өндөр эрэлтийг зөөллөхөд дэмжлэг үзүүлсээр ирсэн хандлага ажиглагдаж байна. Төвбанкны эх үүсвэрийн дээрх дэмжлэгийн үр дүнд

системийн хэмжээнд тооцсон заавал байлгах нөөцийн хэмжээ нийт эх үүсвэрийн 28 хувьд хүрч өмнөх 11 дүгээр сарын 15.8 хувиас огцом өсчээ (11 дүгээр сард ЗБН-ийн хэмжээ нь Төвбанкнаас тогтоосон 12 хувийн ЗБН-ийн харьцаатай ойролцоо байсан юм).


Зээлийн өсөлт саарсан орчинд Төвбанк 2016 оны 1 дүгээр сарын 14-нд бодлогын хүүгээ 12 хувьд хүргэн, 1 нэгж хувиар буруулав. Банкны зээлийн өсөлт (орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасыг оруулж тооцсон) жилийн 2.7 хувьд хүрсэн, чанаргүй зээлийн хэмжээ нийт зээлийн 7.1 хувьтай тэнцсэн, инфляци жилийн 2 хувиас доош буурч ирсэн орчинд Төвбанк бодлогын хүүг бууруулах шийдвэр гаргав.

Төсвийн алдагдал 2015 онд 1,163 тэрбум төгрөгт хүрсэн нь сүүлийн тодотголоор батлагдсан түвшин болох 1,176 тэрбум төгрөгийн алдагдалд дөхөж очив. Өнгөрсөн оны төсвийн орлого 5,976 тэрбум төгрөг болж 2014 оны төсвийн орлогын гүйцэтгэлтэй харьцуулахад 5.4 хувиар буурч гарчээ. Ийнхүү төсвийн орлого татарсан нь голчлон НӨАТ, гадаад худалдааны татварын дутуу гүйцэтгэлээс шалтгаалав. Харин шатахууны өндөр татвар болон АМНАТ зэрэг нь төсвийн хүндрэлтэй орчинд төсвийн орлогод дэмжлэг боллоо. Орлогын тасалдалтай орчинд нийт зардал 7,136 төгрөгийн гүйцэтгэлтэй байж өмнөх 2014 оны гүйцэтгэлтэй ойролцоо гарав. Орлого өнгөрсөн оны 1 дүгээр сарын төсвийн эхний тодотголын орлогын төсөөлөлтэй харьцуулахад 10 хувийн буюу 600 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Энэ нь төсвийн орлогыг бодитой төсөөлөх шаардлага байгааг сануулж байна.

Зураг 5. Монголын ЗГ-ын бондын өгөөж 1 дүгээр сарын сүүлд 11%-ийг давсан нь сонгогдсон бусад орнуудтай харьцуулахад огцом өсөлт байлаа.


Зураг 6. Төвбанк банкны секторт оны эцэст их хэмжээний санхүүгийн эх үүсвэр нийлүүлсэн бөгөөд бодлогын хүүгээ энэ оны 1 дүгээр сард 12% болгон буурууллаа.

Засгийн газрын бондын өгөөжүүд (%)



Эх үүсвэр: Төвбанк, Bloomberg

Төвбанкны банкны секторт олгосон санхүүгийн эх үүсвэр болон бодлогын хүү



Шигтгээ: Орон сууны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн шинэ тогтолцооны тэсэл

Өнгөрсөн 1 дүгээр сард бодлого боловсруулагчид орон сууцны зээлийн хүүг 8%-аас 5% болгох болон урьдчилгаа төлбөрт дэмжлэг үзүүлэх замаар орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн дэмжих, мөн түүчлэн Төвбанкны тэнцэлд одоогоор байгаа орон сууцны зээлийн активыг ЗГ-т шилжүүлэх санал боловсруулсан.

Төвбанкнаас орон сууцны зээлийн активыг шилжүүлэх санаачлагыг Дэлхийн банк дэмжиж байгаа ч дор дурьдсан зүйлсийг цаашид хууль, журам болон авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүддээ сайтар анхааран үзэх нь зүйтэй:

- Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг төсвийн зардлаар бүртгэж, санхүүжилтийг Төвбанкнаас гаргах бүс нэгдсэн төсөвт суулгах.
- Уг хөтөлбөрийг санхүүжүүлэх зардлыг төсөвт суулгаж, ялангуяа төсвийн хүндрэлтэй байгаа өнөөгийн нөхцөлд төсвийн бусад зардлуудтай ач холбогдлоор нь харьцуулан эрэмбэлэх.
- Уг хөтөлбөрийн зорилтот бүлгийг илүү нарийвчлан тодорхойлсноор төсөвт ирэх ачааллыг бууруулахын зэрэгцээ бага, дунд орлоготой иргэдэд орон сууц худалдан авахад нь үр дүнтэй дэмжлэг үзүүлэх.
- Засгийн газар Төвбанкны орон сууцны зээлийн активыг хэрхэн барагдуулах нь тодорхойгүй байна. Зохих шийдэл олж чадаагүй тохиолдолд Төвбанкны тэнцэлд ихээхэн хэмжээний алдагдал үүсэхээр байна.

Эдийн засгийн идэвхжил саарч буй орчинд Төвбанкнаас эх үүсвэр олгох эсвэл төсвийн дэмжлэгийг үргэлжлүүлэн ашиглах замаар орон сууцны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлж, улмаар барилгын салбарыг дэмжих нь хэр үр дүнтэй бөгөөд зохистой арга хэмжээ болохыг нарийн судалж үзэх нь зүйтэй.